

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2008 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 270/89

Улаанбаатар хот

Гадаад гүйлгээний тайлан гаргах
зааврыг батлах тухай

Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дугаар заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар”-ын дагуу гадаад гүйлгээний төлбөрийн баримтуудад гүйлгээний утгыг харилцагчаар дэлгэрэнгүй тодорхой бичүүлж, хяналт тавин, ажиллахыг арилжааны банкны болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-ын гүйцэтгэх захирлуудад тус тус даалгасугай.

3. Гадаад гүйлгээний тайлангаар авсан мэдээллийн нууцлалыг мөрдөж ажиллахыг Монголбанкны Валютын газар (Г.Дэлгэрмаа)-т, мэдээллийн баазийн хадгалалт, нууцлалыг хамгаалж ажиллахыг Мэдээллийн Технологийн газар (Д.Довчинбазар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 383 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Валютын газар (Г.Дэлгэрмаа), Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газар (Н.Оюунчимэг)-т тус тус үүрэг болгосугай.



Гадаад гүйлгээний тайланг гаргах заавар

Хэсэг 1. Үндсэн ойлголт 0014

- 1.1 Арилжааны банк болон гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь өөрийн болон харилцагчдын хийсэн гадаад гүйлгээний тайланг энэхүү зааврын хавсралт 1-ээр баталсан маягтын дагуу бэлтгэж, Монголбанкны Валютын газарт албан тоотоор /гарын үсэг, тамгаар баталгаажуулсан/ болон э-шуудангаар /э-мэйл/ сар бүрийн 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 1.2 Гадаад гүйлгээний тайланг зөвхөн улсын төлбөрийн тэнцлийн статистик нэгтгэлийг гаргахад ашиглах бөгөөд гадаад гүйлгээний тайлангаар авсан мэдээллийн нууцлалыг Монголбанк чандлан хадгална.
- 1.3 Төлбөрийн тэнцэл нь Эдийн засгийн харьяат болон Эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалыг харуулдаг статистик нэгтгэл юм.

“Эдийн засгийн харьяат” /цаашид харьяат гэх/ гэдэгт дараахь аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүс хамрагдана. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
- Гадаад орнуудад 1 жил хүртэл хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага ба тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар,
- Монгол Улсаас гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт,
- Гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол Улсын иргэд,

"Эдийн засгийн харьяат бус" /цаашид харьяат бус/ гэдэгт дээрх ангилалд үл хамрагдах гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

1.4 Энэ тайланд тусгагдах гадаад гүйлгээнд дараахь дансуудаар хийгдсэн гүйлгээнүүд хамрагдана. Үүнд:

- 1.4.1 Ностро данс/ Гадаадын банкинд нээсэн дотоодын банкны данс/
- 1.4.2 Лоро данс /Дотоодын банкинд нээсэн гадаадын банкны данс /
- 1.4.3 Дотоодын банкинд нээсэн Эдийн засгийн харьяат бус-ын харилцах ба хадгаламжийн данс
- 1.4.4 Эдийн засгийн харьяат ба Эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдэх гүйлгээний бусад данс
- 1.4.5 Онлайн дээр суурилагдсан гадаад гуйвуулгын систем /Western Union, Money Gram гэх мэт/

1.5 Монголбанк шаардлагатай гэж үзвэл 1.4 дахь заалтад заасан дансуудын валютын гүйлгээний баримтын хуулбарыг гаргуулан авна.

Хэсэг 2. Гадаад гүйлгээний тайланг гаргах аргачлал

2.1 Гадаад гүйлгээний тайлангийн маягтанд (Хавсралт 1) тусгагдсан үзүүлэлтүүдийг дараахь байдлаар бөглөнө. Үүнд:

Гүйлгээний дугаар

- Тайлант сард хийгдсэн бүх гүйлгээг 1-ээс эхлэн дугаарлана. Гүйлгээний дугаарыг тухайн гүйлгээний талаар мэдээ авахад ашиглана.

Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он

- Гүйлгээ хийгдсэн сар, өдөр, оныг дараахь дараалал, хэлбэрээр бичнэ. Үүнд:

Сар/өдөр/он Жишээ: 1/16/2008

Гүйлгээний утга

Код

- Харилцагчдын төлбөрийн баримтанд бичсэн гүйлгээний утгыг үндэслэн гүйлгээ тус бүрт Хавсралт 2-т заасны дагуу код онооно. Гүйлгээний кодуудад харгалзах үзүүлэлтүүдийн утгыг “Гүйлгээг ангилах үндсэн зарчим”-аас харж болно (Хавсралт 3). Кредит болон дебит гүйлгээг тусад нь ялгаж кодлох ба гүйлгээний утгыг дараахь байдлаар ойлгоно. Үүнд:

	<i>Кредит</i>	<i>Дебет</i>
<i>I. Урсгал данс</i>	Барааны экспорт Үйлчилгээний орлого Цалин, хөрөнгө оруулалтын орлого Гадаадаас шилжүүлсэн бүх төрлийн шилжүүлэг, тусламж	Барааны импорт Үйлчилгээний зарлага Цалин, хөрөнгө оруулалтын зарлага Гадаадад шилжүүлсэн бүх төрлийн шилжүүлэг, тусламж
<i>II. Хөрөнгө ба санхүүгийн данс</i>	Гадаадаас авсан хөрөнгө Гадаад пассивын өсөлт Гадаад активын бууралт	Гадаадад гаргасан хөрөнгө Гадаад пассивын бууралт Гадаад активын өсөлт

Төлбөр шилжүүлэгч

- Гүйлгээ хийж байгаа харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний нэр болон түүнтэй холбоотой бусад мэдээллийг бичнэ.

Төлбөр хүлээн авагч

- Гүйлгээг хүлээн авч байгаа харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний нэр болон түүнтэй холбоотой бусад мэдээллийг бичнэ.

Зориулалт

- Харилцагчдаас төлбөрийн тэнцлийн баримтанд бичсэн гүйлгээний утгыг дэлгэрэнгүй хэлбэрээр бичнэ. Банк нь Монголбанкны гаргасан зөвлөмжийн дагуу гадаад гүйлгээний төлбөрийн баримтуудад гүйлгээний утгыг банкны харилцагчдаар дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж байна.

Валют

- Гүйлгээ хийсэн валютын кодыг олон улсын валютын зах дээр ашиглагддаг стандартын дагуу бичнэ.

Гүйлгээний дүн: үндсэн валютаар

- Бүх гүйлгээг тухайн валютаар илэрхийлсэн дүнгээр бичнэ. Мөнгөн дүнг мянгачилж тооцно.

Гүйлгээний дүн: ам.доллараар

- Гүйлгээний дүнг мянган ам. доллараар бүртгэнэ. Ам. доллараас бусад валютаар хийгдсэн гүйлгээг Монголбанкнаас зарласан тухайн өдрийн ханшаар ам. долларт хөрвүүлнэ.

Гүйлгээнд оролцогч эсрэг талын код /улсын код/

- Маягтын энэ нүдэнд гүйлгээнд оролцогч эсрэг талын харьяалагдаж байгаа орны кодыг бичнэ. Улсын кодыг оруулахдаа орнуудын нэрсийг үсгийн дарааллаар жагсаасан Хавсралт 4-ийг ашиглана. Хүснэгтэнд тусгайлан кодлогдоогүй орнуудыг оршин байгаа тивийг харгалзан бусад орнууд гэсэн тэмдэглэлийг ашиглан кодлоно.

2.2 Маягтыг бөглөх явцад тодруулах зүйл гарвал Монголбанкны Валютын газрын Төлбөрийн тэнцэл, судалгааны албанд хандана. (bop@mongolbank.mn, факс: 322173, утас: 327088)

2.3 Гадаад гүйлгээний тайлан гаргах маягтыг “Unicode” текст форматаар бөглөнө.

Хариуцлага

- Энэ зааварт оруулсан мэдээллийг үнэн зөв, зохих журмын дагуу бүрдүүлээгүй этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага ногдуулна.

----- оОо -----

Гадаад гүйлгээний
тайланг гаргах зааврын
Хавсралт №1

. . . . -НЫ ГАДААД ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Байгууллагын нэр)

оны сар

Дугаар	Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он	Гүйлгээний утга				Гүйлгээний дүн (Үндсэн валютаар, мянгачилж)			Гүйлгээний дүн (Мянган ам.доллараар)		Гүйлгээнд оролцогч эсрэг талын код /орон/
		Код	Төлбөр шилжүүлэгч	Төлбөр хүлээн авагч	Зориулалт	Валют	Кредит	Дебет	Кредит	Дебет	
Нийт	*****	****	*****	*****	*****	*****	*****	*****			*****

Гадаад гүйлгээний тайланг гаргасан:

Нягтлан бодогч /

Тамга

Хянасан:

Захирал /

ГҮЙЛГЭЭНИЙ КОД

	Гүйлгээний код	
	Кредит	Дебет
I. УРСГАЛ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ		
A. БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН		
1. Экспорт		
1.1 Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний төлбөр	1111	
1.2 МАА-н бусад түүхий эд	1112	
1.3 Зэсийн баяжмал	1113	
1.4 Алт	1114	
1.5 Нүүрс	1115	
1.6 Нефть	1116	
1.7 Бусад эрдэс бүтээгдэхүүн	1117	
1.8 Бусад	1118	
2. Импорт		
2.1 Хүнсний бараа бүтээгдэхүүн		2111
2.2 Бусад өргөн хэрэгцээний бараа бүтээгдэхүүн		2112
2.3 Үйлдвэрийн тоног төхөөрөмж		2113
2.4 Барилгын материал		2114
2.5 Шатахуун, тосолгооны материал		2115
2.6 Тээврийн хэрэгсэл		2116
2.7 Гэр ахуйн бараа бүтээгдэхүүн		2117
2.8 Бусад		2118
B. ҮЙЛЧИЛГЭЭ		
1. Тээврийн үйлчилгээ		
1.1 Ачаа тээвэр	1211	2211
1.1 Зорчигч тээвэр	1212	2212
1.3 Бусад	1213	2213
2. Даатгал		
2.1 Хураамж	1221	2221
2.2 Нөхөн төлбөр	1222	2222
3. Аялал жуулчлал		
3.1 Жуулчлал	1228	2228
3.2 Эмчилгээ	1229	2229
3.3 Сургалт	1230	2230
3.4 Бусад	1231	2231
4. Харилцаа холбооны үйлчилгээ	1232	2232
5. Барилгын үйлчилгээ	1233	2233
6. Компьютер ба мэдээллийн үйлчилгээ	1234	2234
7. Хууль зүй, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө	1235	2235
8. Урлаг, соёлын үйлчилгээ	1237	2237
9. Хөдөө аж ахуй, геологи хайгуулын үйлчилгээ	1238	2238
10. Навигаци	1239	2239
11. Санхүүгийн үйлчилгээ		
11.1 Аккредитивын шимтгэл	1240	2240

11.2 Санхүүгийн лизингийн шимтгэл	1241	2241
11.3 Бусад	1242	2242
12. Патент, тэмдэгт, лицензийн хураамж		
12.1 Патент, лицензийн хураамж	1243	2243
12.2 Франчайзийн эрхийн хураамж	1244	2244
12.3 Бусад	1245	2245
13. Бусад үйлчилгээ	1246	2246

В. ОРЛОГО /ЗАРЛАГА/

1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	1311	2311
2. Ногдол ашиг	1312	2312
3. Бүх төрлийн үнэт цаасны хүү	1313	2313
4. Зээлийн хүү	1314	2314
5. Хадгаламжийн хүү	1315	2315
6. Бусад	1316	2316

Г. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ

1. Албан ёсны тусламж	1411	2411
2. Хувийн гуйвуулга ба шилжүүлэг	1412	2412
3. Бусад шилжүүлэг		
3.1 Хандив, тусламж	1414	2414
3.2 Бусад	1415	2415

II. ХӨРӨНГӨ БА САНХҮҮГИЙН ДАНС

А. ХӨРӨНГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

а. ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛЭГ

1. Засгийн газар		
Хүчингүй болгосон өр	1506	2506
Газар	1507	2507
2. Бусад салбар		
Шилжин суугчдын шилжүүлэг	1508	2508
Хүчингүй болгосон өр	1509	2509

б. Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгийн эзэмшил/шилжүүлэг

	1510	2510
--	------	------

Б. САНХҮҮГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

а. ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Актив /гадагш хийсэн хөрөнгө оруулалт/

1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	1511	2511
1.2 Бусад	1512	2512
2. <i>Пассив /гадаадаас орж ирсэн хөрөнгө оруулалт/</i>		
2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	1513	2513
2.2 Бусад	1514	2514

б. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Актив /гадагш хийсэн хөрөнгө оруулалт/

Хувьцаа	1611	2611
Бонд	1612	2612
Өрийн бичиг	1613	2613
Бусад бүх төрлийн үнэт цаас	1614	2614

2. Пассив /гадаадаас орж ирсэн хөрөнгө оруулалт/

Хувьцаа	1615	2615
Бонд	1616	2616

Өрийн бичиг	1617	2617
Бусад бүх төрлийн үнэт цаас	1618	2618

в. БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Актив /гадагш хийсэн хөрөнгө оруулалт/

1.1 Урт хугацаат зээл

Төв банк	1711	2711
Засгийн газар	1712	2712
Банкууд	1713	2713
Бусад	1714	2714

1.2 Богино хугацаат зээл

Төв банк	1721	2721
Засгийн газар	1722	2722
Банкууд	1723	2723
Бусад	1724	2724

1.3 Бэлэн мөнгө ба харилцах

Төв банк	1731	2731
Засгийн газар	1732	2732
Банкууд	1733	2733
Бусад	1734	2734

1.4 Бусад актив

Төв банк	1741	2741
Засгийн газар	1742	2742
Банкууд	1743	2743
Бусад	1744	2744

2. Пассив /гадаадаас орж ирсэн хөрөнгө оруулалт/

2.1 Урт хугацаат зээл

Төв банк	1715	2715
Засгийн газар	1716	2716
Банкууд	1717	2717
Бусад	1718	2718

2.2 Богино хугацаат зээл

Төв банк	1725	2725
Засгийн газар	1726	2726
Банкууд	1727	2727
Бусад	1728	2728

2.3 Бэлэн мөнгө, харилцах

Төв банк	1735	2735
Банкууд	1736	2736

2.4 Бусад пассив

Төв банк	1745	2745
Засгийн газар	1746	2746
Банкууд	1747	2747
Бусад	1748	2748

ТУСГАЙ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

Буцсан гүйлгээ	1811	2811
----------------	------	------

Гүйлгээг ангилах үндсэн зарчим

УРСГАЛ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН

Бараа бүтээгдэхүүн. Бараа бүтээгдэхүүнд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдэх үл хөдлөх хөрөнгөнөөс бусад бүх төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт ба импортын үйл ажиллагаа буюу нэг эзэмшигчээс нөгөөд бүрмөсөн эсвэл шилжин эзэмшигдэх эрхээр хангагдах бараа, бүтээгдэхүүний гүйлгээ тусгагдана.

Экспорт. Харьятаас харьяат бусад хил давуулж нийлүүлсэн бараа, мөнгөжөөгүй алт, боомтод нийлүүлсэн бараа орно. "Боомтод нийлүүлсэн бараа" гэж гадаадын галт тэрэг, онгоцонд нийлүүлсэн шатахуун ба бусад материал болон татваргүй барааны дэлгүүрийн харьяат бусад борлуулсан барааг хэлнэ.

Импорт. Харьят бусаас харьяатад хил давуулж нийлүүлсэн бараа, боомтод нийлүүлсэн бараа, мөнгөжөөгүй алт орно. Тусламжийн шугамаар, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж мөн хамрагдана.

ҮЙЛЧИЛГЭЭ

Тээврийн үйлчилгээ. Бүх төрлийн тээврийн хэрэгслээр хийгдсэн зорчигч болон ачаа тээвэрлэлт, бараа материал ачиж буулгах, бусад туслах чанарын ажил үйлчилгээг хамруулна. Мөн тээврийн хэрэгслийг жолоодох багийн хамт түрээслэх үйлчилгээ хамрагдана.

Даатгалын үйлчилгээ. Эдийн засгийн харьяат бус-д эдийн засгийн харьяат /эдийн засгийн харьяатад эдийн засгийн харьяат бус/ даатгалын байгууллагын зүгээс үзүүлсэн бүх төрлийн даатгалын үйлчилгээ орно. Энэ ангилалд экспортлосон ба импортлосон ачаа барааг даатгасан үйлчилгээний хөлс, амь даатгал, эд хөрөнгө, давхар даатгал гэх мэт бүх төрлийн даатгалууд хамрагдана.

Аялал жуулчлал. Эдийн засгийн харьяат бус-аас Монгол улсад /Монгол улсын иргэд гадаад орнуудад/ байх хугацаандаа хувийн болон албан хэрэгцээндээ хэрэглэх зорилгоор худалдан авсан бараа, үйлчилгээнд /боловсрол, эрүүл мэнд/ төлсөн төлбөрүүд энэ ангилалд хамаарна. Оюутнууд, эмчилгээ сувиллын зорилгоор Монгол улсын иргэн гадаадад зорчсон болон гадаадын иргэд Монгол улсад зорчсон тохиолдолд тухайн оронд байх хугацаанаас хамаарахгүйгээр энэ бүлэгт орно.

Харилцаа холбооны үйлчилгээ. Харилцаа холбооны үйлчилгээнд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд холбооны хэрэгсэлээр дамжин хийгдэж байгаа үйлчилгээнүүд орно. Үүнд, телефон, захидал, хэвлэл, илгээмж, электрон шуудан, бүх төрлийн агаарын шугам, сүлжээтэй холбоотой үйлчилгээнүүд багтана.

Барилгын үйлчилгээ. Барилгын үйлчилгээнд барилгын компани, тэдгээрийн ажиллагсаас тухайн орны эдийн засгийн нутаг дэвсгэрт тодорхой хугацаанд барьж байгаа барилга байгууламж, тэдгээрийн монтаж засал чимэглэлтэй холбоотой хийгдсэн үйлчилгээнүүд хамрагдана. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын барилгын компаний салбар, охин компаний хийж гүйцэтгэсэн барилгын ажил энэ ангилалд орохгүй.

Компьютер ба мэдээллийн үйлчилгээ. Энэ төрлийн үйлчилгээнд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдсэн компьютерын программ хангамж, мэдээлэл солилцоо, тооцоолон бодох техникийн зөвлөгөө, мэдээллийн сан байгуулах, компьютерын засвар зэрэг үйлчилгээнүүд багтана.

Санхүүгийн үйлчилгээ. Энэ төрлийн үйлчилгээнд банкны зээлийн шугам, аккредитив, санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг, гадаад валютын гүйлгээ, брокерын үйлчилгээ зэрэг санхүүгийн зуучлалын үйлчилгээний төлбөр ба шимтгэлүүд багтана.

Патент, тэмдэгт, лицензийн хураамж. Үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө болох худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг ашиглах, франчайзингийн эрхийн хураамж ба үйлдвэрлэгчийн давуу эрх, бүтээлийн бүрэн эхийг ашиглах эрхийн хураамжууд орно.

Бусад үйлчилгээ. Эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдсэн дээр дурьдсанаас бусад төрлийн үйлчилгээнүүд багтана.

ОРЛОГО /ЗАРЛАГА/

Эдийн засгийн харьяатаас харьяат буст төлсөн цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогууд энэ бүлэгт багтана.

Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад орнуудын элчин сайдын яам ба консулын газарт ажиллаж буй дотоодын ажиллагсдын цалин түүнтэй адилтгах орлого ба хөрөнгө оруулалтын хүүгийн орлого ба зардлыг бүртгэнэ.

Санхүүгийн үйл ажиллагаагаар хүлээсэн үүрэгтэй холбоотой гарсан орлого, зарлагын гүйлгээ хамрагдана. Үүнд, шууд хөрөнгө оруулалттай холбоотой энгийн ба давуу эрхтэй хувьцааны ногдол ашиг, үнэт цаасны хүү, хямдруулалт, бүх төрлийн зээл ба хадгаламжийн хүүтэй холбоотой хийгдсэн гүйлгээнүүд багтана.

Хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох орлого. Үүнд шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашиг (дивиденд), түүнээс хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогыг бүртгэнэ.

Зээлийн хүүний орлого. Зээлийн хүүний орлогод бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгслүүдийн хүү, санхүүгийн деривативын гүйлгээнээс олсон хүүний орлогыг бүртгэнэ.

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ

Эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд хөрөнгийн ба санхүүгийн хэрэгслүүдийг өмчлөх эрхтэйгээр шилжүүлж байгаа гүйлгээнүүд багтана. Урсгал шилжүүлэг нь албан ёсны ба хувийн гэж ангилагдана. 2 орны засгийн газар, түүний харьяаны байгууллагууд, олон улсын байгууллагуудын хооронд хийгдсэн бэлэн мөнгө ба бараа материалын тусламжийг албан ёсны, гадаад орнуудад ажиллаж байгаа ажиллагсдын мөнгөн гуйвуулга, бэлэг дурсгал, сугалааны ашиг, өв хөрөнгө шилжүүлэг зэрэг нь хувийн гуйвуулгад багтана.

Засгийн газрын шилжүүлэг

Үүнд Засгийн газрын өөр улсын Засгийн газар болон олон улсын байгууллагатай хийсэн дараахь төрлийн гүйлгээг бүртгэнэ. Үүнд:

- төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар олгосон мөнгөн тусламж,
- байгалийн болон бусад гамшигийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслэлийн тусламж,
- олон улсын байгууллагын гишүүнчлэлийн татвар, олон улсын байгууллагаас гишүүний асуудлаар засгийн газарт шилжүүлсэн шилжүүлэг,
- олон улсын байгууллага, гадаадын Засгийн газрын техник туслалцааны хүрээнд ажиллагсдын цалин, бусад холбогдох зардлуудын санхүүжилт.

Ажилчдын гуйвуулга

Гуйвуулга гэдэгт мөнгөн болон биет хэлбэрийн гуйвуулгыг ойлгоно. Кредит тал дээр гадаад орнуудад 1 ба түүнээс дээш жилээр ажиллаж буй Монгол иргэдээс Монгол Улс уруу илгээсэн гуйвуулгыг, дебет тал дээр Монгол Улсад 1 ба түүнээс дээш хугацаагаар ажиллаж буй гадаадын иргэдийн гадаад орнууд руу шилжүүлсэн гуйвуулгыг бүртгэнэ.

Бусад шилжүүлэг

Дараахь гүйлгээнүүдийг орлогод бүртгэнэ. Үүнд:

- ан агнах, загас барих эрхийн хураамжийн төлбөр
- олон улсын улаан загалмайн байгууллага, гадаад орнуудын шашны болон сайн дурын, урлаг соёлын байгууллага зэрэг төрийн бус байгууллагуудын шугамаар байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслэлийн тусламж, мөнгөн хандив,
- гадаад орнуудад болсон спорт, урлагын болон бусад тэмцээний шагнал, сугалааны хонжворын шагнал, бусад шагнал

Дараахь төрлийн гүйлгээг зарлагад бүртгэнэ. Үүнд:

- олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагуудад шилжүүлсэн гишүүнчлэл, хандивын шилжүүлэг,
- гадаад орнуудад болох спорт, урлагын болон бусад тэмцээний тасалбарын Монгол Улсад борлуулсан орлого.

ХӨРӨНГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

Хөрөнгийн дансны гүйлгээг хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Хөрөнгийн шилжүүлэг

Хөрөнгийн шилжүүлэгт үндсэн хөрөнгийн өмчлөгч эзэн өөрчлөгдсөн, зээлийг хүчингүй болгосноор өглөг зээлдэгчийн хөрөнгө болсон, үндсэн хөрөнгө худалдан авахаар шилжүүлсэн бэлэн мөнгө, элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжүүлсэн газрын шилжүүлгийн гүйлгээнүүд багтана. Эдгээрийг Засгийн газар болон бусад гэсэн эдийн засгийн сектораар бүртгэж, бусад секторт Төв банк, арилжааны банк, аж ахуйн нэгжийг нэгтгэж харуулна.

Газар

Монгол улсад суугаа гадаадын элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжсэн газрын төлбөрийг орлогод харин зарлага тал дээр гадаад орнуудад суугаа Монголын элчин сайдын яамны худалдан авсан газрын төлбөрийг бүртгэнэ.

Хүчингүй болгосон өр

Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн өрийг хүчингүй болгосон тохиолдолд зээлдэгч орлогын гүйлгээ хийж харин зээлдүүлэгчийн тал зарлагын гүйлгээний бичилт хийнэ.

Шилжин суугчдын шилжүүлэг

Шилжин суугчид гэж гадаад оронд сурах, эмчлүүлэх, аялах зорилгоор зорчигчдоос бусад нэг жилээс дээш хугацаагаар амьдрахаар явсан иргэдийг хэлнэ. Шилжин суугчдын шилжүүлэг гэж гадаад орон уруу амьдрахаар явах үедээ шилжүүлсэн гэр ахуй, хувийн хэрэглээний зүйлс, хөдлөх хөрөнгө (машин гэх мэт), санхүүгийн хөрөнгийг (харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл, үнэт цаас гэх мэт) ойлгоно.

Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө

Энд үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө болох худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг худалдан авсан, худалдсантай холбоотой шилжүүлгийн гүйлгээ бичигдэнэ.

САНХҮҮГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Шууд хөрөнгө оруулалтанд хамтарсан болон гадаадын шууд хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газруудад тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад зохих нөлөө үзүүлэхүйц урт хугацаанд оруулсан хөрөнгүүдийг тооцно. Шууд хөрөнгө оруулалт нь тухайн улсаас гадагшаа хийсэн болон гадаадаас орж ирсэн хөрөнгийн урсгалыг багтаана. Шууд хөрөнгө оруулалтанд хувь нийлүүлсэн хөрөнгө, дахин хөрөнгө оруулалтанд тооцсон ашиг, бусад хөрөнгө оруулалтуудыг хамруулна.

Төлбөрийн тэнцлийн аргачлалын дагуу энгийн хувьцаа эсвэл санал өгөх эрхийн 10-аас дээш хувийг шууд хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа тохиолдолд шууд хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газарт тооцно.

Хувь нийлүүлсэн хөрөнгө. Үүнд хөрөнгө оруулагчийн анхны нийлүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваарилагдсан ногдол ашгийг буцааж оруулсан хөрөнгө, гаднаас нэмж оруулсан хөрөнгийг тус тус бүртгэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлс зэрэг биет болон мөнгөн хэлбэрээр байна.

Бусад хөрөнгө. 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай компани, түүний салбар, харьяа нэгжээ байгуулах зорилгоор гадаадаас орсон, гадаадад нийлүүлсэн хөрөнгийг бүртгэнэ.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Санхүүгийн хөрөнгө оруулалт гэж хувьцаа, бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгсэл болон санхүүгийн деривативуудад байршуулсан хөрөнгө оруулалтыг хэлнэ. Санхүүгийн хөрөнгө оруулалтын гүйлгээг хөрөнгийн хувьцаа болон өрийн бичгүүд гэсэн 2 үндсэн төрлөөр, эдийн засгийн дөрвөн сектороор (Төв банк, засгийн газар, арилжааны банк ба аж ахуйн нэгж) тус тусад нь бүртгэнэ. Актив данс нь харьяат бусаас авах авлагыг пассив нь харьяат бусад төлөх өглөгийг харуулна.

БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэ бүлэгт бүр төрлийн зээлийг (тухайлбал, арилжааны, хөнгөлөлттэй, урт хугацааны, богино хугацааны, худалдааны зээл гэх мэт) хамруулахаас гадна арилжааны банкуудын ностро харилцах, хадгаламж болон арилжааны банкууд дээр байгаа лоро харилцах, хадгаламж болон бусад актив/пассив орно. Зээлийг урт болон богино хугацаатай гэсэн 2 ангиллалаар үзүүлнэ. 1 хүртэлх жилийн хугацаатай зээлийг богино хугацааны, 1 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг урт хугацааны зээлд бүртгэнэ.

Бусад хөрөнгө оруулалтанд Эдийн засгийн харьяат ба Эдийн засгийн харьяат бус-ын хооронд хийгдсэн дараахь санхүүгийн гүйлгээнүүд багтана. Үүнд:

1. Урт ба богино хугацаат зээл
2. Бэлэн мөнгө, харилцах ба хадгаламж
3. Бусад авлага ба өглөг

Бэлэн мөнгө ба харилцах. Үүнд арилжааны банкны ностро/лоро харилцах данс, ностро/лоро хадгаламжийн данс, банкны касет байгаа болон банкнаас гадуур гүйлгээнд байгаа бэлэн валютын гүйлгээг ойлгоно. Гадаадын банкинд байгаа ностро харилцах, хадгаламжийн дансны гүйлгээг дебет, кредитээр актив талд бүртгэж, харьяат бусын Монголын арилжааны банкинд нээсэн лоро харилцах, хадгаламжийн дансны гүйлгээг пассив талд дебет, кредитээр харуулна.

Бусад актив/пассив

Олон улсын байгууллагуудад байршуулсан Монгол Улсын хувь хөрөнгийн дансны гүйлгээг бусад актив/пассивт бүртгэнэ. Актив тал дээр олон улсын байгууллагуудад байршуулсан манай хувь хөрөнгийн өөрчлөлтийг, пассив талд олон улсын байгууллагын мэдлийн хувь хөрөнгийн дансны өөрчлөлтийг харуулна.

ТУСГАЙ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ

БУЦСАН ГҮЙЛГЭЭ

Эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бус-ын хооронд банк, ББСБ-аар дамжин хийгдсэн урсгал болон санхүүгийн дансны гүйлгээнүүдээс тодорхой шалтгааны улмаас буцсан гүйлгээнүүдийг бүртгэнэ.

ОРНУУДЫН КОД

Дараалал	Орнууд	Код	Дараалал	Орнууд	Код									
А	Австрали	036	Н	Норвеги	578									
	Австри	040		О	Оросын Холбооны улс	643								
	Албани	008			П	Пакистан	586							
	Америк	840				Р	Польш	616						
	Англи	826					С	Португаль	620					
	Азербейжан	031						Т	Румын	642				
	Арабын Эмират	784							У	Саудын Араб	682			
	Аргентин	032								Ф	Сингапур	702		
	Армен	051									Х	Сири	760	
	Б	Бангладеш										050	Ц	Словак
Беларус		112	Э									Солонгос (хойд)		408
Бельги		056		Ю								Солонгос (өмнөд)		410
Болгар		100			Я							Тажикстан		762
Бразил		076				Бусад орнууд /тивээр/						Тайвань		158
В	Вьетнам	704					Австрали тив					Тайланд		764
	Г	Герман						276				Ази тив		Турк
Гонг-Конг		344						Америк тив	Туркменистан					795
Д	Голланд	528							Африк тив	Узбекистан				860
	Грек	300								Европ тив	Украйн			804
	Гүрж	268									Югослав		Унгар	348
	Е	Дани	208										Япон	Филиппин
		Египет	818	Бусад орнууд /тивээр/										Финлянд
И	Индонези	360	Эстони		Франц									250
	Израль	376			Энэтхэг	Хорват								191
	Иордан	400				Югослав	Хятад							156
	Иран	364					Япон					Чех		203
	Ирак	368						Бусад орнууд /тивээр/				Чили		152
	Ирланд	372							Австрали тив			Швед		752
	Исланд	352								Ази тив		Шинэ Зеланд		554
	Испани	724									Америк тив	Швейцари		756
	Итали	380										Африк тив	Эстони	233
	К	Казакстан		398									Европ тив	Энэтхэг
Канад		124	Бусад орнууд /тивээр/	Югослав										891
Киргизстан		417		Япон	Япон									392
Куба		192			Бусад орнууд /тивээр/									
Кувейт		414				Бусад орнууд /тивээр/								
Л	Лаос	418					Бусад орнууд /тивээр/							
	Латви	428						Бусад орнууд /тивээр/						
	Литви	440							Бусад орнууд /тивээр/					
	Люксембург	442								Бусад орнууд /тивээр/				
М	Макао	446									Бусад орнууд /тивээр/			
	Малайз	458										Бусад орнууд /тивээр/		
	Мексик	484	Бусад орнууд /тивээр/											
	Молдав	498		Бусад орнууд /тивээр/										
	Монако	492			Бусад орнууд /тивээр/									

Гадаад гүйлгээний тайлан гаргах жишээ:

Гүйлгээ 1. “А” банк тус бүр 100,000.0 иений нэрлэсэн үнэтэй 1 жилийн хугацаатай Японы Засгийн газрын 300 ширхэг бондыг худалдан авчээ. Энэхүү хөрөнгө оруулалт нь тус банкинд сар бүр 500,000.0 иений бондын хүүгийн орлого авчрах ажээ. Бондын төлбөрийг 2008 оны 1 дүгээр сарын 2-нд шилжүүлсэн ба эхний сарын хүүгийн орлого 2008 оны 1 дүгээр сарын 31-нд орж иржээ.

Гүйлгээ 2. “А” банкны харилцагч, Монгол Улсын иргэн, 2008 оны 1 дүгээр сарын 23-нд америкийн ABC компаниас Ford Expedition маркийн автомашин худалдан авч автомашины үнэ болох 31,000.0 ам.долларыг өөрийнхөө банкаар шилжүүлжээ.

Гүйлгээ 3. “А” банк Германы Дрезднер банкнаас 3 жилийн хугацаатай 75,000.0 еврогийн зээл авчээ. Авсан зээл нь 2008 оны 1 дүгээр сарын 10-нд тус банкны дансанд орж иржээ.

Дээрхи гүйлгээнүүд 1 сард хийгдсэн гэж үзвэл гадаад гүйлгээний тайланг дараахь байдлаар гаргана.

Тайлангийн мэдээг

шалгах, боловсруулах, нэгтгэх ажлыг стандартчлах, автоматжуулах үүднээс “Unicode” форматаар бөглөнө.

* * * * *

Монголбанкны Ерөнхийлөгчийн ... оны .. сарын .. өдрийн ... тоот тушаалын .. дугаар хавсралт

“А” БАНКНЫ ГАДААД ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2008 оны 1 сар

Дугаар	Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он	Гүйлгээний утга				Гүйлгээний дүн (Үндсэн валютаар, мянгачилж)			Гүйлгээний дүн (Мянган ам.доллараар)		Гүйлгээнд оролцогч эсрэг талын код /орон/
		Код	Төлбөр шилжүүлэгч	Төлбөр хүлээн авагч	Зориулалт	Валют	Кредит	Дебет	Кредит	Дебет	
1	01/08/2008	2612	А банк	Японы засгийн газар	Бонд худалдаж авав	JPY		30000.00		260.00	392
2	01/10/2008	1717	Дрезднер	А банк	Зээл авав	EUR	75.00		102.00		276
3	01/23/2008	2119	Иргэн	ABC ХХК	Автомашины төлбөр	USD		31.00		31.00	840
4	01/31/2008	1313	Японы засгийн газар	А банк	Хүүгийн орлого	JPY	500.00		4.70		392
Нийт	*****	*****	*****	*****	*****	*****	*****	*****	106.70	291.00	*****

Гадаад гүйлгээний тайланг гаргасан:

Нягтлан бодогч / / Тамга

Хянасан:

Захирал..... /

¹ “А” банкнаас Японы Засгийн газрын бондыг худалдан авах нь санхүүгийн хөрөнгө оруулалтын актив данс буюу гадагш хийсэн хөрөнгө оруулалтанд тооцогдоно. Актив данс нэмэгдэх нь дебит гүйлгээгээр /Зааврыг харна уу/ илэрхийлэгдэх ба Санхүүгийн хөрөнгө оруулалт-Актив-Бонд гэсэн дансны дебит гүйлгээний утганд 2612 гэсэн код/ Хүснэгт 1-ийг харна уу/ харгалзаж байна.

² Монгол улсын иргэн Америкийн компаниас автомашин худалдан авах нь бараа бүтээгдэхүүний импортонд тооцогдоно. Бараа бүтээгдэхүүний импорт /Машин, тоног төхөөрөмж/ буюу дебит гүйлгээний утганд 2119 гэсэн код /Хүснэгт1-ийг харна уу/ харгалзаж байна.